

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/159/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023.02.17	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2023.08.17 № 2/47

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар тус байгууллага нь урсгал үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу Баянхонгор аймгийн Соёл урлагийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлж байна.

### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн

D- alban bichig 2022 A4 TOOT

005020239

төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>298,188,451.00</b>	<b>368,708,489.32</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	1,811,172.32
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	1,811,172.32
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	1,811,172.32
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,811,172.32
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	298,188,451.00	366,897,317.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	258,500.00	201,500.00
35110	Тусгай зориулалттай материал	258,500.00	201,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	295,379,951.00	364,145,817.00
35410	Бичиг хэргийн материал	6,124,682.00	5,959,592.00
35420	Аж ахуйн материал	33,740,150.00	26,489,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	3,300,000.00
35450	Барилгын засварын материал	80,000.00	80,000.00
35470	Бусад хангамжийн материал	255,435,119.00	328,317,125.00
35600	Мал амьтад	2,550,000.00	2,550,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,092,484,852.69</b>	<b>1,014,220,370.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,092,484,852.69	1,014,220,370.38
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	881,174,852.99	802,615,370.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,635,330,707.66	1,635,330,707.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-913,625,714.52	-943,094,808.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,874,999.84	-46,874,999.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	343,414,182.60	349,094,182.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-287,400,020.09	-314,595,420.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,891,503.00	167,891,503.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-144,146,405.82	-158,021,394.56
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	37,000,000.00	37,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,250,000.00	6,250,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,250,000.00	-6,250,000.00
39217	Ном	585,600.00	885,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	211,309,999.70	211,604,999.85
39301	Програм хангамж	450,000.00	2,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	246,687,355.00	246,687,355.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-35,377,355.30	-36,762,355.15
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,390,673,303.69</b>	<b>1,382,928,859.70</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>274,381.00</b>	<b>296,170.67</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	274,381.00	296,170.67
<b>413</b>	<b>Өглөг</b>	274,381.00	296,170.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	228,489.67
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	67,681.00	67,681.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	67,681.00	67,681.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,390,398,922.69</b>	<b>1,382,632,689.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,390,398,922.69	1,382,632,689.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	945,688,163.91	945,688,163.91
51101	Өмч: - төрийн	945,688,163.91	945,688,163.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-55,364,711.91	-63,130,945.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-55,364,711.91	-55,364,711.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,766,233.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	500,075,470.69	500,075,470.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,390,673,303.69</b>	<b>1,382,928,859.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,075,670,717.00</b>	<b>1,175,940,270.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>68,245,667.00</b>	<b>58,999,470.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	68,245,667.00	58,999,470.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	25,855,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	25,855,470.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,007,425,050.00</b>	<b>1,116,940,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	872,921,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	872,921,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,221,750.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон замагт орлого	28,221,750.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	979,203,300.00	244,019,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	979,203,300.00	244,019,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,059,008,372.52</b>	<b>1,183,706,503.66</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,059,008,372.52</b>	<b>1,183,706,503.66</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	996,114,497.44	1,107,955,442.47
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	588,838,128.14	660,793,777.18
210101	Үндсэн цалин	550,570,128.14	550,271,322.06
210102	Нэмэгдэл	00.00	47,454,923.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,268,000.00	36,492,000.00
210104	Урамшуулал	00.00	6,494,817.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	20,080,715.12
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	82,391,164.60	82,621,276.49
210201	Тэтгэврийн даатгал	60,419,812.49	56,184,216.49
210202	Тэтгэмжийн даатгал	5,754,000.00	6,612,320.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,701,016.91	5,283,217.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,013,164.00	1,321,274.26
210205	Эрүүл мэндийн даатгал	10,503,171.20	13,220,248.22
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	198,417,243.18	216,932,616.70
210301	Гэрэл, цахилгаан	3,253,627.18	5,972,271.70
210302	Түлш, халаалт	190,313,200.00	204,886,733.00
210303	Цэвэр, бохир ус	4,850,416.00	6,073,612.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,837,414.00	21,265,203.79
210401	Бичиг хэрэг	1,727,100.00	4,428,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,317,400.00	6,263,221.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,233,614.00	2,125,906.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	901,500.00	1,198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,657,800.00	7,249,576.00
2105	<b>Нормативт зардал</b>	182,200.00	625,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	182,200.00	625,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,722,500.00	12,460,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	248,500.00	1,790,000.00
210604	Урсгал засвар	2,474,000.00	10,670,400.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,893,000.00	554,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,893,000.00	554,000.00

**Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,349,423.00	26,778,586.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	11,687,948.00	25,358,716.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	94,000.00	297,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,750.00	239,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,525.00	77,000.00
210807	Газрын төлбөр	806,200.00	806,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	63,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	97,483,424.52	85,924,482.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,070,199.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,413,225.52	85,924,482.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	62,893,875.08	75,751,061.19
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	61,810,887.50	71,255,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,716,596.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,594,291.50	69,489,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,765,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,082,987.58	4,495,761.19
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	340,000.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	742,987.58	4,495,761.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>16,662,344.48</b>	<b>-7,766,233.66</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	30,520,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	30,520,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-30,520,000.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-13,857,655.52</b>	<b>-7,766,233.66</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,009,919,997.00</b>	<b>1,142,796,270.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>25,855,470.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	25,855,470.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	25,855,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	25,855,470.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,009,919,997.00</b>	<b>1,116,940,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	872,921,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	872,921,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,716,697.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,716,697.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	979,203,300.00	244,019,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	979,203,300.00	244,019,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,004,619,997.00</b>	<b>1,133,325,097.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,004,619,997.00</b>	<b>1,133,325,097.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>941,726,121.92</b>	<b>1,057,574,036.49</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	593,670,292.74	660,771,987.51
210101	Үндсэн цалин	555,475,060.55	550,249,532.39
210102	Нэмэгдэл	00.00	47,454,923.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,195,232.19	36,492,000.00
210104	Урамшуулал	00.00	6,494,817.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	20,080,715.12

**Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,559,000.00	82,621,276.49
210201	Тэтгэврийн даатгал	54,543,000.00	56,184,216.49
210202	Тэтгэмжийн даатгал	5,754,000.00	6,612,320.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,603,200.00	5,283,217.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,150,800.00	1,321,274.26
210205	Эрүүл мэндийн даатгал	11,508,000.00	13,220,248.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	198,417,243.18	216,932,616.70
210301	Гэрэл, цахилгаан	3,253,627.18	5,972,271.70
210302	Түлш, халаалт	190,313,200.00	204,886,733.00
210303	Цэвэр, бохир ус	4,850,416.00	6,073,612.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,099,414.00	15,080,777.79
210401	Бичиг хэрэг	1,928,500.00	2,925,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,317,400.00	6,263,221.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,244,714.00	2,125,906.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,408,800.00	2,568,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,652,000.00	3,974,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,652,000.00	3,974,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,100,000.00	11,208,526.00
210602	Тавилга	00.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	2,468,626.00
210604	Урсгал засвар	10,800,000.00	8,539,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,893,000.00	554,000.00
210702	Дотоод албан томилолт	1,893,000.00	554,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	46,335,172.00	46,430,402.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,594,497.00	46,430,402.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,350.00	00.00
210807	Газрын төлбөр	806,200.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	142,200.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	20,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	20,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,893,875.08</b>	<b>75,751,061.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	61,810,887.50	71,255,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,310,887.50	69,489,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,765,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,082,987.58	4,495,761.19
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	340,000.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	742,987.58	4,495,761.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,300,000.00</b>	<b>9,471,172.32</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,300,000.00</b>	<b>7,660,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,300,000.00</b>	<b>7,660,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,300,000.00	7,660,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,300,000.00	7,660,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-5,300,000.00</b>	<b>-7,660,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>1,811,172.32</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>1,811,172.32</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	945,688,163.91	492,075,470.69	-41,232,675.39	1,396,530,959.21
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	945,688,163.91	492,075,470.69	-41,232,675.39	1,396,530,959.21
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,857,655.52	-13,857,655.52
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	945,688,163.91	500,075,470.69	-55,364,711.91	1,390,398,922.69
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	945,688,163.91	500,075,470.69	-55,364,711.91	1,390,398,922.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	945,688,163.91	500,075,470.69	-55,364,711.91	1,390,398,922.69
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,766,233.66	-7,766,233.66
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	945,688,163.91	500,075,470.69	-63,130,945.57	1,382,632,689.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,161,982,800.00	1,136,489,336.49	25,493,463.51	97.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,161,982,800.00	1,136,489,336.49	25,493,463.51	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,090,725,300.00	1,065,234,036.49	25,491,263.51	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,303,600.00	660,771,987.51	531,612.49	99.9
210101	Үндсэн цалин	565,217,600.00	550,249,532.39	14,968,067.61	97.4
210102	Нэмэгдэл	37,437,200.00	47,454,923.00	-10,017,723.00	126.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,568,000.00	36,492,000.00	2,076,000.00	94.6
210104	Урамшуулал	00.00	6,494,817.00	-6,494,817.00	
210105	Гэрээт ажлын хөлс	20,080,800.00	20,080,715.12	84.88	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,663,200.00	82,621,276.49	41,923.51	99.9
210201	Тэтгэврийн даатгал	56,210,800.00	56,184,216.49	26,583.51	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,613,100.00	6,612,320.29	779.71	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,290,500.00	5,283,217.23	7,282.77	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,322,600.00	1,321,274.26	1,325.74	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	13,226,200.00	13,220,248.22	5,951.78	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,428,000.00	216,932,616.70	4,495,383.30	98.0
210301	Гэрэл, цахилгаан	8,852,600.00	5,972,271.70	2,880,328.30	67.5
210302	Түлш, халаалт	206,236,800.00	204,886,733.00	1,350,067.00	99.3
210303	Цэвэр, бохир ус	6,338,600.00	6,073,612.00	264,988.00	95.8
2104	Хангамж, бараа материалын зардал	15,479,800.00	15,380,777.79	99,022.21	99.4
210401	Бичиг хэрэг	3,230,500.00	3,225,100.00	5,400.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	6,317,400.00	6,263,221.00	54,179.00	99.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,160,000.00	2,125,906.79	34,093.21	98.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,198,000.00	2,000.00	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,571,900.00	2,568,550.00	3,350.00	99.9
2105	Нормативт зардал	4,000,000.00	3,974,450.00	25,550.00	99.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	3,974,450.00	25,550.00	99.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,072,000.00	13,008,526.00	63,474.00	99.5
210602	Тавилга	4,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	50.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	2,468,626.00	-1,968,626.00	493.7
210604	Урсгал засвар	8,572,000.00	8,539,900.00	32,100.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	563,200.00	554,000.00	9,200.00	98.4
210702	Дотоод албан томилолт	563,200.00	554,000.00	9,200.00	98.4

**Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	52,215,500.00	51,990,402.00	225,098.00	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,215,500.00	51,990,402.00	225,098.00	99.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,000,000.00	20,000,000.00	20,000,000.00	50.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000,000.00	20,000,000.00	20,000,000.00	50.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	71,257,500.00	71,255,300.00		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	71,257,500.00	71,255,300.00	2,200.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,489,500.00	69,489,500.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,768,000.00	1,765,800.00	2,200.00	99.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,161,982,800.00	1,138,300,508.81	23,682,291.19	98.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	872,921,600.00	872,921,600.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	872,921,600.00	872,921,600.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	244,019,200.00	239,523,438.81	4,495,761.19	98.2
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	45,042,000.00	25,855,470.00	19,186,530.00	57.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,042,000.00	25,855,470.00	19,186,530.00	57.4
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	1,811,172.32	-1,811,172.32	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	60.00	60.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь “Монголын соёлын урлагийн үнэт өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчлах, орчин үеийн уран бүтээлийн чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрөөс баримтлах соёлын бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан асуудлыг бие даан хэрэгжүүлэх” зорилго тавин ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс 2018 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,744.4 мянга буюу 0.6 хувиар төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	298,188.5	21.4%	368,708.5	26.7%	70,520.0	23.6%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	1,811.2	0.1%	1,811.2	0.0%
Авлага	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	298,188.5	21.4%	366,897.3	26.5%	68,708.9	23.0%
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,092,484.9	78.6%	1,014,220.4	73.3%	(78,264.5)	-7.2%
Үндсэн хөрөнгө	2,512,609.3	180.7%	2,520,269.3	182.2%	7,660.0	0.3%
Хуримтлагдсан элэгдэл	(1,420,124.5)	-102.1%	(1,506,049.0)	-108.9%	(85,924.5)	6.1%
<b>Нийт хөрөнгө</b>	1,390,673.3	100.0%	1,382,928.9	100.0%	(7,744.4)	-0.6%
Өр төлбөр	274.4	0.0%	296.2	0.0%	21.8	7.9%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,390,398.9	100.0%	1,382,632.7	100.0%	(7,766.2)	-0.6%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,390,673.3	100.0%	1,382,928.9	100.0%	(7,744.4)	-0.6%

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь үндсэн дансны үлдэгдэл 1,811.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 366,897.3 мянган төгрөг болж 68,708.9 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгсэл данс 3,300.0 мянга, бусад хангамжийн материал данс 72,882.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,520,269.3 мянган төгрөг болж 7,660.0 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 7,660.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад хөрөнгийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,382,632.7 мянган төгрөг болж 7,766.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 7,766.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,419,746.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,419,746.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 257,764.0 мянган төгрөгөөр бууруулж 1,161,982.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 872,921.6 мянга, орон нутгийн төсвөөс 244,019.2 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 45,042.0 төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр улсын төсвөөс 872,921.6 мянга, орон нутгийн төсвөөс 244,019.2 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 25,855.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,136,489.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,136,489.3 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,495.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 20,000.0 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71702 Соёл урлаг</b>	<b>1,161,982,800.00</b>	<b>1,136,489,335.91</b>	<b>25,493,464.09</b>	<b>97.8%</b>
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	762,664,100.00	763,946,908.00	-1,282,808.00	100.0%
3	80214 Уран бүтээл хийлгэх	40,000,000.00	39,994,540.00	5,460.00	99.9%
4	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	45,042,000.00	22,769,149.10	22,272,850.90	50.6%
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	70,257,500.00	70,255,300.00	2,200.00	99.9%
6	80112 Нийтлэг үйлчилгээ	244,019,200.00	239,523,438.81	4,495,761.19	98.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагын өөрийн орлого болох 14,242.1 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрснийг 2022 оны 06 дугаар сард үндсэн данс руу төвлөрүүлж зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээ сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,059,282.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,889.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,122.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны дотоод албан томилолтоос 1,934.6 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Харин өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12.1 хувь, бичиг хэргийн зардлыг 63.7 хувь, тээвэр шатахууны зардлыг 57.6 хувиар өсгөсөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого

зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 1,262,806.3 мянган төгрөгийн 36 мэдээлэл, 6.4.8-д "Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл"-д заасан 23,584.1 мянган төгрөгийн 18 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Харин хуулийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 78,228.8 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож, 111,363.1 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 38,865.5 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг огт мэдээлээгүй, 6.4.8-д "Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл"-д заасан 15,689.0 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож, 39,458.0 мянган төгрөгийн 12 мэдээллийг мэдээллийг мэдээлээгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж аудитаар 28,219.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 227,824.5 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.30-ны өдрийн 70 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	
Албан шаардлага	1	28,219.1	1	28,219.1	100
Зөвлөмж	4	227,824.5	4	227,824.5	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>256,043.6</b>	<b>5</b>	<b>256,043.6</b>	<b>100</b>

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус байгууллагын өөрийн орлого, заалны түрээсийн орлогыг авч үзэх шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,359.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1517.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 3,842.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант хугацааны шатахууны зардлыг тулгахад 198.7 мянган төгрөгийн шатахууныг замын хуудасгүйгээр зарцуулсан, мөн Тээвэр шатахууны зардлаас 1318.3 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар туслах мал аж ахуйд зарцуулсан байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан шатахууны үнийг Холбогдох албан тушаалтнаар буцаан төлүүлэх, үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зарцуулдаг явдлыг таслан зогсоож, гарсан зардлыг туслах аж ахуйн орлогоос орон нутгийн орлогын бусад татвар хураамжийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 78,228.8 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг хугацаа хоцроож, 111,363.1 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 38,865.8 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн хуулийн 6.4.8-д заасан төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 39,458.0 мянган төгрөгийн 12 шийдвэр, халаалтын гэрээг мэдээлээгүй, 15,689.0 мянган төгрөгийн 7 шийдвэрийг хугацаа хоцроож тус тус мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан 189,686.9 мянган төгрөгийн 19 гүйлгээг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2-д заасны дагуу горим сорил хэрэгжүүлэхэд өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12.1 хувь, бичиг хэргийн зардлыг 63.7 хувь, тээвэр шатахууны зардлыг 57.6 хувиар өсгөсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж бичиг хэрэг болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант хугацааны урсгал засварын зардлаас зарцуулсан 3,300.0 мянган төгрөгийн сэлбэгийг авч зарцуулахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг зөрчиж байна.

**Өгсөн зөвлөмж:** Хууль журмыг хэрэгжүүлж тээврийн хэрэгслийн сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын ӨХЗ-өөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж ажиллах.

2. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Байгууллагын даргын 2022.07.21-ний өдрийн А/22 дугаар тушаалаар аймгийн 80 жилийн ойтой холбогдуулан байгууллагын гадна гэрэлтүүлэг хийх зорилгоор 542.5 мянган төгрөгийн туузан гэрлийг уран бүтээлийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урсгал засварын зардлаас зарцуулсан 3300.0 мянган төгрөгийн сэлбэгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.	1	3,300.0					1	3,300.0
Тайлант хугацааны шатахууны зардлыг тулгахад 198.7 мянган төгрөгийн шатахууныг замын хуудасгүйгээр зарцуулсан, мөн Тээвэр шатахууны зардлаас 1318.3 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар туслах мал аж ахуйд зарцуулсан байна.	1	1,517.0	1	1,517.0				
Байгууллагын даргын 2022.07.21-ний өдрийн А/22 дугаар тушаалаар аймгийн 80 жилийн ойтой холбогдуулан байгууллагын гадна гэрэлтүүлэг хийх зорилгоор 542.5 мянган төгрөгийн туузан гэрлийг уран бүтээлийн зардлаас зарцуулсан байна.	1	542.5					1	542.5
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>5,359.5</b>	<b>1</b>	<b>1,517.0</b>			<b>2</b>	<b>3,842.5</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2-д заасны дагуу горим сорил хэрэгжүүлэхэд өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12.1 хувь, бичиг хэргийн зардлыг 63.7 хувь, тээвэр шатахууны зардлыг 57.6 хувиар өсгөсөн байна.	1	0			1	0		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 78228.8 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг хугацаа хоцроож, 111363.1 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 38865.8 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн хуулийн 6.4.8-д заасан төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 39458.0 мянган төгрөгийн 12 шийдвэр, халаалтын гэрээг мэдээлээгүй, 15689.0 мянган төгрөгийн 7 шийдвэрийг хугацаа хоцроож тус тус мэдээлсэн байна.	1	0			1	0		
Дүн	<b>2</b>	<b>0</b>			<b>2</b>	<b>0</b>		

-----oOo-----